

## Монгол улс, БНХАУ хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, цаашдын хамтран ажиллах чиглэл

Н.Отгонсайхан \*

Д.Нарандалай \*\*

*Товч агуулга:* Манай хоёр орны Засгийн газар 1990-ээд оны эхэн үед худалдааны шинэ хэлэлцээр, хөрөнгө оруулалтын хэлэлцээрт гарын үсэг зурсан нь хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хэмжээг ихээхэн нэмэгдүүлсэн. 1990 онд Монгол Улсаас БНХАУ-тай хийсэн худалдаа 34 сая ам.доллар, 1990-2000 онд БНХАУ-аас Монгол Улсад оруулсан гадаадын илүүд хөрөнгө оруулалт 441.1 сая ам.доллар байсан бол 2013 оны байдлаар худалдааны нийт эргэлт 5.5 тэрбум ам.доллар, хөрөнгө оруулалт 3.8 тэр бум ам.доллар болтлоо өссөн. 2013 оны эцсийн байдлаар БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэд 52.1 хувь, экспортод 86.8 хувь, импортод 28.7 хувь, ГШХО-д 26.6 хувийг эзэлж хамгийн том түнш болсон. Түүнчлэн Монгол Улсад оруулсан гадаадын илүүд хөрөнгө оруулалтын хэмжээ болон бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжийн тоогоороо бусад хөрөнгө оруулагч орнуудыг тэргүүлж байна. Иймд энэ хугацаанд хийгдсэн худалдаа, хөрөнгө оруулалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, Монгол улсад ямар үр өгөөжтэй байгааг тодорхойлох, цаашид үр ашигтай хамтран ажиллах боломж нөхцлийг эрэлхийлэх нь чухал байгаа юм. Энэхүү шлтгэлээр Монгол улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтад БНХАУ-ын эзлэх байр суурь, гарч буй хүндрэл, цаашид хамтран ажиллах чиглэлийг тодорхойлохыг зорилоо.

\* МУИС, Бизнесийн сургууль, Ph.D, и-мэйл: [otgonsaikhan@num.edu.mn](mailto:otgonsaikhan@num.edu.mn)

\*\* МУИС, Бизнесийн сургууль, и-мэйл: [narandalai@num.edu.mn](mailto:narandalai@num.edu.mn)

**Түлхүүр үг.** Монгол Улс, БНХАУ, гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалт

*Abstract. Bilateral trade and investment flows have substantially increased via new trade and investment agreements, which Chinese and Mongolian government has signed in the early 1990s. In 1990, trade turnover between Mongolia and China was \$34 million and foreign direct invest*

*ment from China between 1990-2000 was \$441.1 million. But, in 2013, total trade turnover and investment has increased to \$5.5 billion and \$3.8 billion respectively. It represents 52.1 percent of total trade turnover, 86.8 percent of export, 28.7 percent of import and 26.6 percent of FDI. Furthermore, China is leading other investors by value of FDI and numbers of registered enterprises in Mongolia. Therefore, it is needed to analyze FDI inflows and its economic effects in Mongolia and seek the opportunity to work together more efficiently with China. This article aims to analyze China's position in Mongolian foreign trade and investment and identify the areas of future cooperation.*

**Keywords.** Mongolia, PRC, foreign trade, foreign direct investment

**1. Монгол улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалт**


Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд гадаад худалдаа чухал байр суурь эзэлж, өргөжин тэлсээр байна. Зах зээлийн шилжилтийн эхэн үед гадаад худалдаа уналтад орж 1991 онд өмнөх онтой харьцуулахад 57 орчим хувиар буурч худалдааны эргэлт 708.9 сая ам.долларт хүрч байсан бол 1990-ээд оны дунд үеэс тогтвортой өссөн. 2000 онд худалдааны эргэлт анх удаа 1.0 тэрбум ам.долларт хүрснээс хойш дэлхийн эдийн засгийн хямралын үеийг эс тооцвол тасралтгүй өсч 2003 он гэхэд 1990 оны худалдааны эргэлтэд дөхөж очиж байсан билээ. Үүнээс хойш 2011 онд экспорт 4817.5 сая ам.доллар, импорт 6598.4 сая ам.долларт хүрч, нийт бараа эргэлт өмнөх оноос 5307.3 сая ам.доллар буюу 86.9 хувиар, экспорт 1909.0 сая ам.доллар буюу 65.6 хувиар, импорт 3398.3 сая ам.доллараар буюу 2.1 дахин өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт юм.

Харин 2013 онд 135 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт урьдчилсан дүнгээр 10627.4 сая ам.долл, үүнээс экспорт 4272.7 сая ам.долл, импорт 6354.7 сая ам.долларт хүрсэн нь 2012 оныхоос 495.7 сая ам.доллар буюу 4.5 хувь, экспорт 112.0 сая

## ОЛОН УЛС СУДЛАЛ

ам.доллар буюу 2.6 хувь, импорт 383.7 сая ам.доллар буюу 5.7 хувиар буурчээ.


Гадаад худалдааны тэнцэл 1994-1995 оны боловсруулах үйлдвэрийн сэргэлт, 2006 оны эдийн засгийн өсөлтийг дагуулсан экспортын барааны гадаад зах зээлийн үнийн өсөлтийн оргил үед ашигтай бусад онуудад алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2012 онд алдагдлын хэмжээ түүхэндээ байгаагүй өндөр түвшинд буюу 2.4 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 32 хувиар буюу 573.4 сая ам.доллараар, 2010 онтой харьцуулахад 8 дахин өсчээ (Зураг 1.).



Зураг 1. Монгол Улсын гадаад худалдаа, сая ам доллар. (1990-2013)

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувьд 1990 оноос хойш гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж, урамшуулахад нэлээд анхаарал тавьсантай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт хурдацтайгаар нэмэгдсээр ирсэн. 1991 онд 11.1 сая ам.доллар байсан гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 оны эцэс гэхэд дэлхийн 110 гаруй орны хөрөнгө оруулалт бүхий 12.8 мянган аж ахуйн нэгж бүртгэгдэж, нийт 16.2 тэрбум ам.доллар шууд хөрөнгө оруулалт орсон байна. Монгол Улсад орсон ГШХО-ын 60 орчим хувь нь сүүлийн гурван жилийн хугацаанд буюу 2010 оноос геологи, уул уурхайн салбарт “Оюу Толгой” төсөл хэргэжиж эхэлсэнээр хийгдсэн. Зөвхөн 2011 онд гэхэд өмнөх оноос 5 дахин их буюу 5 тэрбум ам.доллар ГШХО

орсон бол төслийн санхүүжилттэй холбоотойгоор 2012 онд ГШХО-ын хэмжээ өмнөх оноос 18 хувиар буурч 4.1 тэрбум ам.доллар, 2013 онд өмнөх оноос 44 хувиар буурч 2.29 тэрбум ам.доллар болсон байна.



Зураг 2. Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Монгол улсын гадаад худалдааны газарзүйн байршлыг авч үзвэл, 2013 онд нийт 60 оронд экспортын худалдаа хийснээс нийт үнийн дүнгийн 97.2 хувь нь экспортын гол түнш таван оронтой<sup>1</sup> хийсэн худалдаанд ногдож байна. Харин дэлхийн 137 орны бараа импортолсноос барааны гарал үүслээр нь авч үзвэл импортын гол түнш таван орноос<sup>2</sup> нийт импортынхоо 75.8 хувийг хангасан байна.

Бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг эх үүсвэрээр нь авч үзвэл нийт ГШХО болон ГХО-тай ААН-ийн тооны 81 хувь нь мөн Хятад зэрэг цөөн хэдэн улсад ногдож байгааг хүснэгт 1-ээс харж болно.

Хүснэгт 1. Монгол Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын гол түнш орнууд

Гадаад худалдаа /2013 он, сая ам.доллар/					
Гол түнш орон	Экспорт		Гол түнш орон	Импорт	
	үнийн дүн	эзлэх хувь		үнийн дүн	эзлэх хувь
БНХАУ	3,700.30	86.70	БНХАУ	1,785.80	28.1
Их Британи	200.70	4.70	ОХУ	1,561.90	24.6
Канад	135.50	3.20	АНУ	512.70	8.1
ОХУ	61.80	1.40	БНСУ	507.40	8.0

<sup>1</sup> БНХАУ, Их Британи, Канад Улс, ОХУ, Итали

<sup>2</sup> БНХАУ, ОХУ, АНУ, БНСУ, Япон

ОЛОН УЛС СУДЛАЛ

Итали	51.50	1.20	Япон	444.20	7.0
Нийт	<u>4.149.80</u>	<u>97.20</u>		<u>4.812.00</u>	<u>75.8</u>
<i>Гадаадын шууд хөрөнгө оруулалт /1990-2013 он, сая ам.доллар/</i>					
Гол түнш орон	Дотогшлох урсгал		Гол түнш орон	ГХО-тай ААН	
	үнийн дүн	эзлэх хувь		тоо	эзлэх хувь
Нидерланд	4,200	29.96	БНХАУ	6,249	48.80
БНХАУ	3,750	26.65	БНСУ	2,261	17.66
Люксембург	1,150	8.17	ОХУ	838	6.54
Виржини Арлууд	1,100	7.87	Япон	539	4.21
Сингапур	720	5.14	АНУ	300	2.34
Канад	490	3.53	Виржини Арлууд	258	2.01
Нийт	<u>11.41</u>	<u>81.32</u>		<u>10.445</u>	<u>81.6</u>

Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг салбараар нь авч үзвэл нийт хөрөнгө оруулалтын 94 орчим хувь нь гадаад зах зээлд экспортлох боломж бүхий өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдгүй салбаруудад орсон байна. Тухайлбал 73.6 хувь нь геологи, уул уурхай, 16.6 хувь нь худалдаа нийтийн хоол, 1.4 хувь нь банк санхүү, 1.3 хувь нь тээвэр, 0.9 хувь нь инженерийн барилга байгууламжийн салбарууд тус тус ногдож байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 73.6 хувь нь ногдож байгаа геологи, уул уурхай, эрэл хайгуулын салбарын бүтээгдэхүүнүүд нь экспортод голлох хувийг эзэлж байна. Тухайлбал, эрдэс бүтээгдэхүүний экспорт 2000 онд 35.2 хувь, 2005 онд 42.7 хувь, 2010 онд 81 хувь, 2012 онд 91 хувийг тус тус эзэлж, нийт экспортод эзлэх хувь хэмжээ нь өсөн нэмэгдсээр байна. 2013 онд эрдэс бүтээгдэхүүний экспортын 99.2 хувийг чулуун нүүрс, зэсийн баяжмал, молибдений баяжмал, хайлуур жонш, төмрийн хүдэр, цайрын хүдэр болон боловсруулаагүй газрын тосны экспорт эзэлж байна.


Монгол Улсаас экспортын харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүнүүд<sup>3</sup> нь БТКУС-ийн 02, 05, 25, 26, 27, 41, 51, 57, 61, 71, 74-р бүлгүүд байгаа ба эдгээрээс 05, 26-р бүлгийн барааны хувьд харьцангуй давуу тал хамгийн өндөр, өрсөлдөх чадвар сайтай байгаа бол нэмүү өртөг шингэсэн салбар болох 61, 57 бүлгийн бараа сүүлийн жилүүдэд өрсөлдөх чадваргүй болсон байна. Харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүний дийлэнх хувийг Рикардогийн бүтээгдэхүүн буюу олборлох үйлдвэрлэл, мал аж ахуйн гаралтай түүхий эд зэрэг байгалийн баялагт түшиглэсэн бүтээгдэхүүн эзэлж байна. Хөнгөн үйлдвэрлэлийн салбар дахь хөрөнгө оруулалт бага байгаа нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хөгжил сул байгаагийн нэг гол шалтгаан болж байна. Экспортын барааны нэр төрөл хязгаарлагдмал, бүтцэд нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн багахан хувийг эзэлж байгаа тул мал аж ахуйн болон олборлох үйлдвэрлэлд тулгуурласан үйлдвэрлэлийн кластеруудыг хөгжүүлэх, үүндээ хөрөнгө оруулалтыг татах шаардлагатай болох нь салбарууд дахь гадаадын хөрөнгө оруулалт болон экспортын бүтцээс харагдаж байна.

Импортын бүтцийг авч үзвэл, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, бензин, дизелийн түлш, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүн, хүнсний бэлэн бүтээгдэхүүн, хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл 90 гаруй хувийг эзэлдэг.

Манай орны ГШХО-ын гүйцэтгэлийн индекс болон ГШХО-ын потенциалын индексийн олон улсад эзэлж буй байр суурийг харьцуулж үзвэл гүйцэтгэл нь потенциалаасаа дээгүүр үзүүлэлттэй байгаа нь харагдаж байна (Зураг 3). ГШХО-ын гүйцэтгэлийн индексийн утга нь 1-ээс их буюу сүүлийн жилүүдэд хоёр оронтой тоо гарч байгаа нь өөрийн эдийн засгийн чадавхаасаа илүү их хэмжээний ГШХО-ыг татаж чадаж байгааг харуулж байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг ихээр татаж байгаа нь эдийн засгийн өсөлт, хөгжилд эерэг нөлөө үзүүлэх хэдий ч хөрөнгө оруулалтын урсгалыг зөв удирдахгүй бол өртөг нэмэгдсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хөгжил орхигдож, манай улс түүхий эдийн үйлдвэрлэгч орон болж хувираад байгаа нь

<sup>3</sup> Бела Баласса (Balassa, 1965)-ийн харьцангуй давуу талыг тодорхойлох индексээр тооцсон

гадаад худалдааны бүтцээс тодорхой харагдаж байна. Иймээс бусад салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, урамшуулахад анхаарах нь чухал юм.




Зураг 3. Монгол улсын ГНХО-ын гүйцэтгэлийн болон потенциалын индексийн олон улсад эзэлж буй байр суурь

Монгол Улсаас гадаад зах зээлд хийгдэж буй хөрөнгө оруулалтын бүртгэл өнөөг хүртэл хангалтгүй хэвээр байна. Монгол банкны статистик мэдээллээс авч үзвэл Монгол Улсаас гадаадад оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн 6.4 тэрбум ам.доллар ба үүний 19%-ийг (1.22 тэрбум ам.доллар) шууд хөрөнгө оруулалт эзэлж байна. НҮБ-ийн Худалдаа, хөгжлийн хорооны ГНХО, ҮДК-ийн мэдээллийн санд бүртгэгдсэнээр 2001-2012 онуудад Япон, БНСУ, Люксембург, АНУ зэрэг орнуудад Монгол улсаас шууд хөрөнгө оруулалт хийсэн байна. Мөн Олон улсын худалдааны төвийн Хөрөнгө оруулалтын статистикээс үзвэл 2012 онд Монгол улсаас бусад улс орон руу 44 сая ам.доллар шууд хөрөнгө оруулалт хийгдсэн ба энэ нь өмнөх оноос 53%-аар буурсан үзүүлэлт юм. Хэдийгээр олон улсын байгууллагуудын мэдээллийн санд Монгол улсаас бусад оронд хийж буй хөрөнгө оруулалтын статистик тоо баримт бүртгэгдсэн байгаа хэдий ч улс орон тус бүрээр үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо, үйл ажиллагааны хэлбэр, хөрөнгө оруулалтын хэмжээ гэх зэрэг нарийн мэдээлэл байхгүй байна.

## II. Монгол Улс, БНХАУ-ын хоорондын худалдаа, хөрөнгө оруулалт

БНХАУ нь 2013 оны дүнгээр Монгол Улсад орсон нийт ГШХО-ын 26.65 хувь буюу 3.75 тэрбум ам.доллар хөрөнгө оруулалт хийснээр топ хөрөнгө оруулагчдын 2 дугаарт жагсаж байна. Мөн Монгол Улсад бүртгэлтэй аж ахуй нэгжийн тоогоороо Хятад улс нь (6249 ААН буюу нийт ГШХО-тай ААН-ийн 49 орчим хувь) бусад хөрөнгө оруулагч орнуудыг тэргүүлж байна. (Хүснэгт-1)

Гадаад худалдааны хувьд хоёр орны хооронд хийгдэж байсан худалдаа 1990 онд 34 сая ам доллар үүнээс экспорт 11.3 сая ам доллар импорт 22.3 сая ам доллар, 11 сая долларын худалдааны алдагдалтай байсан. Сүүлийн жилүүдэд 2 орны гадаад худалдааны хамтын ажиллагаа өргөжин тэлсээр байна. 2013 оны байдлаар МУ-ын худалдааны нийт эргэлтэд Хятад улс 52.1 хувь, экспортод 86.8 хувь, импортод 28.7 хувийг эзэлжээ. Хятад улстай хийж буй худалдааны тэнцэл эерэг байгаа хэдий ч нийт экспортод эрдэс бүтээгдэхүүн давамгайлж байгаа нь сайн үзүүлэлт биш юм.




Зураг 4. Монгол Улсын БНХАУ-тай хийж буй худалдаа, сая ам доллар. (1990-2013)

БНХАУ-аас Монгол улсад оруулсан шууд хөрөнгө оруулалтын 70 орчим хувь нь геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбар

## ОЛОН УЛС СУДЛАЛ

(68.3) болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын салбарт (0.6) орсон байгаа бол Хятад руу экспортолж буй барааны бүтцэд эрдэс (96%) болон малын гаралтай ноос, ноолуур, арьс шир (3%) гэсэн нэмүү өртөг шингээгүй түүхий эд нийт экспортын 99 хувийг бүрдүүлж байна. Монгол Улсын нийт экспортын 80-90 орчим хувь, Хятадад хийж буй экспортын 97 орчим хувийг зөвхөн эрдэс бүтээгдэхүүн эзэлж байхад БНХАУ-ын тухайн барааны нийт импортод Монгол Улсын экспортын эзлэх хувь дөнгөж 2 хувийг эзэлж байгаа нь Хятадын тал манай экспортоос хамаарал султай байгааг харуулж байна. Эрдэс бүтээгдэхүүн нь БНХАУ-ын нийт импортод 24 орчим хувийг эзэлдэг аж.



Зураг 5. БНХАУ-аас Монгол улсад оруулсан ГШХО, салбараар

Уул уурхайн салбар дахь шууд хөрөнгө оруулалт 2010 оныг эс тооцвол 2007-2011 онуудад өсөлттэй байсан бол 2010 онд өмнөх оноос 77 хувиар буурчээ. Энэ үед мөн дэлхийн уул уурхайн салбарт оруулсан Хятадын ГШХО-ын хэмжээ өмнөх оноос 57 хувиар буурсан байна. БНХАУ-аас Монгол улсын бусад салбарт оруулсан хөрөнгө оруулалтын динамикаас үзвэл худалдаа, нийтийн хоол, тээвэр болон инженерийн барилга байгууламж, барилгын материалын салбар дахь хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд тогтмол буюу жилийн дундаж өсөлт нь тус бүр 29.9, 22.3, 13.9 хувь байна. Харин хөнгөн үйлдвэр, эрчим хүчний салбар дахь шууд хөрөнгө оруулалт зогссон байна.

Хүснэгт 2. БНХАУ-аас Монгол улсад бүртгэгдсэн ГШХО,  
салбараар, тэрбум ам.доллар.


(1990-2013.6.30)

Салбарын нэр	1990-2013	2009	2010	2011	2012*	2013.6.30*
Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тосны салбар	2,563.39	558.18	128.91	683.72	59.99	0.30
Худалдаа, нийтийн хоол	779.66	51.73	43.25	181.65	131.85	21.19
Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл	77.53	1.23	0.85	2.42	36.15	0.85
Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт	23.73	-	0.24	0.66	-	0.04
Хөнгөн үйлдвэр	23.51	0.09	0.10	-	-	-
Тээвэр	17.57	0.03	1.09	0.65	9.36	0.07
Эрчим хүч	3.77	-	-	-	-	-
Аялал жуулчлал	2.65	0.09	0.10	0.27	0.13	0.10
Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл	1.16	-	-	-	-	-
Нийтийн ахуйн үйлчилгээ	0.80	-	-	-	-	-
Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл	0.78	-	-	-	-	-
Бусад	257.47	1.71	1.49	145.90	5.71	2.77
<b>Нийт</b>	<b>3,752.02</b>	<b>613.06</b>	<b>176.04</b>	<b>1,015.27</b>	<b>243.19</b>	<b>25.32</b>

2012\* 4-р улирал, 2013.06.30\*-ны эхний хагас жилийн хөрөнгө оруулалтын мэдээнд Монголбанкны төлбөрийн тэнцлийн мэдээлэл нэмэгдээгүй болно.

## ОЛОН УЛС СУДЛАЛ

Хятад улс уруу экспортолж буй барааны бүтцийг БТКУС-ийн 4 орны түвшинд нарийвчлан сүүлийн 10 жилээр авч үзвэл нүүрс, зэсийн баяжмал, түүхий нефть, төмрийн хүдэр, цайрын баяжмал гэсэн бүтээгдэхүүн эхний байрыг эзэлдэг ба 2007 оноос хойш нийт экспортод 90 гаруй хувийг эзэлж байгаа юм.



Зураг 6. Хятад улс руу экспортолж буй гол нэрийн бүтээгдэхүүн  
/2004-2013 он, хувиар/

Монгол улсаас Хятад улс руу 25, 26, 41, 51, 74-р бүлгийн барааг экспортлох харьцангуй давуу талтай ба эдгээр бүтээгдэхүүний хувьд Хятадын зах зээлд манай улсын бүтээгдэхүүний эзлэх хувь өссөөр байна. Хятад улс эдгээр бүтээгдэхүүний импортоор дэлхийд нэгдүгээр, 27 бүлгээр хоёрдугаар байранд орж байгаагаас үзэхэд эрдэс бүтээгдэхүүн, түүхий эдийн хувьд Хятад улсад эрэлт өндөр байна.

25-р бүлгийн барааны хувьд Монгол Улс Хятадын нийт импортын 0.3 хувийг эзэлдэг боловч мөрийн түвшинд авч үзвэл Монголоос Хятадруу экспортлож буй 25-р бүлгийн барааны 99.9 хувийг хайлуур жонш эзэлж байгаа ба энэ нь Хятадын тухайн барааны импортын 98 хувийг эзэлж байна. Мөн 51-р бүлгийн барааны хувьд Монгол Улс Хятадын нийт импортын 2.7 хувийг эзэлдэг боловч мөрийн түвшинд авч үзвэл Монголоос Хятадруу экспортлож буй 25-р бүлгийн барааны 96.8 хувийг сэмлээгүй, эсвэл самнаагүй мал амьтны үс, ноос, хялгас эзэлж байна. Энэ нь Хятадын тухайн барааны импортын 94.1 хувийг эзэлж байгаа ба Монгол улсын тухайн барааны Хятадын зах зээлд эзлэх хувь өсч байна.

Хүснэгт 3. Монголын экспортын харьцангуй давуу тал бүхий  
бүтээгдэхүүний

Хятадын зах зээл дэх өсөлт

HS	Бүтээгдэхүүн	Монгол Улсаас БНХАУ-ын хийсэн импортын жилийн дундаж өсөлт, 2009- 2013 (%)	Дэлхийн зах зээлээс БНХАУ-ын хийсэн импортын жилийн дундаж өсөлт, 2009- 2013 (%)	БНХАУ тухайн барааны импортоор дэлхийд эзлэх байр суурь
25	Давс; хүхэр; шороон эрдэс, чулуу; шаварлаг эрдэс	30	21	1
26	Хүдэр, баяжмал	19	19	1
27	Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн	38	27	2
41	Арьс, ширэн түүхий эд (ангийн үснээс бусад), боловсруулсан арьс, шир	24	15	1
51	Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас	21	13	1
57	Хивс болон нэхмэл дэвсгэр	-13	10	24
61	Сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэгсэл	16	28	24

Харин Монгол улсын экспортын харьцангуй давуу тал бүхий нэмүү өртөг шингэсэн бараа болох 57, 61 бүлгийн барааны Хятадын зах зээлд эзлэх хувь улам бүр буурсаар байна. Эдгээр бүтээгдэхүүнээр Хятад улс экспортын харьцангуй давуу талтай юм.

## ОЛОН УЛС СУДЛАЛ

Монгол улсын экспортын харьцангуй давуу талтай бүтээгдэхүүн болох түүхий эд, байгалийн баялаг Хятадын импортын харьцангуй давуу талтай ерөнхийдөө давхцаж байгаагаас хоёр орны хоорондох худалдаанд түүхий эдийн худалдаа зонхилох болжээ.

Дээрх нөхцөл байдлаас харахад малын арьс, шир болон үс, ноос, түүнчлэн уул уурхайн хүдэр, баяжмал, зэсийн гол зах зээл нь Хятад улс бөгөөд цаашид БНХАУ-ын импортын харьцангуй давуу тал, Монгол улсын экспортын харьцангуй давуу тал дээр үндэслэн худалдаа хийх нь манай дотоодын зах зээл дээр урт хугацаанд уул уурхайд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлд шаардлагатай стратегийн түүхий эд, мөн арьс шир боловсруулах, ээрмэл, сүлжмэлийн үйлдвэрүүдийн түүхий эдийг худалдан авах өрсөлдөөнийг улам хүчтэй болгож болзошгүй байна.

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжихээс өмнө нийт импортын 80 гаруй хувь нь ОХУ-д ногдож байсан бөгөөд 1990 оноос огцом буурч 30-40 орчим хувийг эзэлж тогтмол эхний байранд явж ирсэн. Гэвч 2008 оноос нийт импортод ОХУ-ын эзлэх хувийн жин буурч 2012 онд 27.4 хувь, 2013 онд 24.6 хувьд хүрч тэргүүлэгч байр сууриа Хятад улсад алджээ<sup>4</sup>.

БНХАУ-аас Монгол улсын импортолж буй барааны эхний 10 бүлэг барааг сүүлийн 3 жилээр авч үзвэл дараах байдалтай байна.

---

<sup>4</sup> 1990 онд БНХАУ -2.4%, ОХУ - 77.5% байсан бол 2011 онд БНХАУ - 30.7%, ОХУ- 24.6%

Хүснэгт 4. БНХАУ-аас Монгол улсын импортолж буй барааны бүтэц  
(сүүлийн 3 жил, хувиар)

HS code	Бүлгийн нэр	БНХАУ-аас импортолсон бараанд тухайн барааны эзлэх хувийн жин			БНХАУ-ын тухайн барааны экспортод Монгол Улруу экспортолсон тухайн барааны эзлэх хувийн жин			БНХАУ-ын нийт экспортод тухайн барааны эзлэх хувийн жин		
		2011	2012	2013	2011	2012	2013	2011	2012	2013
61	Сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэгсэл	14.1	19.2	18.3	0.5	0.6	0.5	4.2	4.2	4.4
84	Цөмийн реактор, уурын тогоо, машин ба механик төхөөрөмж, тэдгээрийн эд анги	15.3	15.1	12.5	0.1	0.1	0.1	18.6	18.3	17.3
27	Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн;	1.5	1.0	7.5	0.1	0.1	0.5	1.7	1.5	1.5
73	Төмөр буюу гангаар хийсэн эдлэл	8.1	6.7	7.2	0.4	0.3	0.3	2.7	2.7	2.6
85	Цахилгаан машин, төхөөрөмж, хэрэгсэл болон тэдгээрийн эд анги	8.4	8.6	6.5	0.1	0.0	0.0	23.5	23.8	25.4
87	Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	15.7	10.3	5.9	0.9	0.5	0.2	2.6	2.7	2.7
72	Хар төмөрлөг	4.0	3.7	5.7	0.3	0.3	0.4	2.1	1.8	1.7
39	Хуванцар болон хуванцар эдлэл	3.5	4.5	5.4	0.2	0.2	0.2	2.4	2.7	2.8

## ОЛОН УЛС СУДЛАЛ

63	Бусад нэхмэл бэлэн эдлэл; хуучин хувцас, нэхмэл эдлэл; хаягдал даавуу.	5.5	5.0	3.9	0.7	0.6	0.4	1.2	1.2	1.2
25	Давс; хүхэр; шороон эрдэс, чулуу; шаварлаг эрдэс, шохой болон цемент	1.9	2.8	3.6	1.5	2.2	2.5	0.2	0.2	0.2
	Total , %	<u>78.0</u>	<u>76.9</u>	<u>76.5</u>	<u>4.8</u>	<u>4.9</u>	<u>5.1</u>	<u>59.2</u>	<u>59.2</u>	<u>59.8</u>

Дээрх хүснэгтээс үзэхэд, Монгол Улсын БНХАУ-аас импортлон авч буй бараа нь нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн болох нэхмэл, сүлжмэл хувцас (HS 61, 63) 25 орчим хувь, тээврийн хэрэгсэл, механик болон цахилгаан машин механизм (HS 84, 85, 87) 25-40 хувь, барилгын материал болох цемент, хар төмөрлөг, ган болон хуванцар бүтээгдэхүүн 20 орчим хувийг эзэлж байгаа юм.

### III. Цаашид хамтран ажиллах чиглэл

Монгол Улсын гадаад худалдааны статистик мэдээллээс үзэхэд, сүүлийн жилүүдэд экспортод эрдэс түүхий эд, харин импортод нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн дийлэнхи хувийг эзэлж байв. Үүнээс үзэхэд түүхий эдийг боловсруулахгүйгээр, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүйгээр, Монгол улсад үр ашиггүй байдлаар худалдаалдаг энэ байдал олон жилийн туршид үргэлжилсээр иржээ.

Иймээс гадаад худалдааг эдийн засагжуулахын тулд дунд хугацаанд Монголын харьцангуй давуу тал болж буй байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, мал аж ахуйн гаралтай түүхий эдэд тулгуурласан үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт татах замаар эдгээрийг тойрсон кластерийг хөгжүүлэх асуудлыг гол зорилтоо болгон түнш орнуудтай хамтран ажиллах хэрэгтэй байна.

Шинээр мөрдөгдөж эхэлсэн<sup>5</sup> “Хөрөнгө оруулалтын тухай” хуулинд хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр барихтай холбоотойгоор импортлосон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болох талаар тусгасан. Иймд цаашид экспортлох боломж бүхий БТКУС-ын 41, 51-р бүлгийн барааны үйлдвэрлэл буюу мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах салбар дахь Хятадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх<sup>6</sup>, мөн эрдэс бүтээгдэхүүний түүхий эдийн нөөцдөө тулгуурлан эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд хамтран ажиллаж, хөрөнгө оруулалтыг татахад<sup>7</sup> анхаарч болох юм. Ялангуяа нүүрсний томоохон орд газруудыг түшиглэсэн цахилгаан станцуудыг барьж байгуулан, эрчим хүчээ Хятадын хил орчмын зах зээлд нийлүүлэх боломж бий.

Мөн хөрөнгө оруулалтын тухай хуулинд эдийн засгийн тусгай бүсэд хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх тохиолдолд эхний 5 жил татвараас чөлөөлөхөөр тусгагдсан ба энэхүү татварын таатай нөхцлийг ашиглан хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд Хятадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулж болох юм.

Монгол улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөрт тусгагдсан асуудлыг яаралтай ажил хэрэг болгох. Үүнд:

- “Талууд хоёр улсын хамтын ажиллагааны тодорхой суурь нөхцөл бүрдсэн хил орчмын бүс нутагт хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах боломжийг идэвхтэй эрэлхийлнэ” гэж заасан. Иймээс Цагааннуур болон Алтанбулаг худалдааны чөлөөт бүс, Замын-Үүд Эдийн засгийн чөлөөт бүсүүдэд БНХАУ-МУ-ОХУ байдлаар үр ашигтай хамтран ажиллах, эдгээр бүсийг БНХАУ-ын тухайлбал, “Хоргос” болон бусад бүсүүдтэй сүлжээ үүсгэн ажлуулах боломж, ач холбогдлыг судалж хэрэгжүүлэх нь зүйтэй боловуу.

<sup>5</sup> 2013.11.01-ээс

<sup>6</sup> БНХАУ-аас Монгол улсад оруулсан ГШХО-ын 0.6% нь мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах салбарт ногдож байна.

<sup>7</sup> БНХАУ-аас Монгол улсад оруулсан ГШХО-ын 0.1% нь эрчим хүчний салбарт ногдож байгаа ба 2005 оноос хойш тус салбарт Хятадын хөрөнгө оруулалт орж ирээгүй.

- “Талууд дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааг идэвхжүүлж, далайд гарцгүй Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг гуравдагч орнуудад экспортлохыг дэмжих бөгөөд 1991 онд байгуулсан “Монгол Улс Хятад Улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулах чиглэлээр хамтран ажиллана” гэж заасныг яаралтай хэрэгжүүлэх, ингэхдээ дамжин өнгөрөх тээвэрлэлтийн салбарт ДХБ-ын хэлэлцээрийн дагуу үндэсний нөхцөл хэрэглэх асуудлыг нэг гол асуудал болгон авч үзэх хэрэгтэй.

- “Талууд гааль, чанарын хяналт шалгалт зэрэг байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах болон амьтан, ургамлын хорио цээрийн хамтын ажиллагааны механизмыг боловсронгуй болгож, бэхжүүлнэ” гэж заасан. Монгол улс хүнсний нийт хэрэглээний 50 гаруй хувийг импортоор хангаж байгаа бөгөөд импортын гурил, цагаан будаа, ногоон цай, хүнсний ногоо, жимс, жимсгэний ихэнх хувийг Хятад улсаас авч байгаа юм. Иймд хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналтыг хамтран хэрэгжүүлэх шаардлагатай байна.

#### **Ашигласан материал:**

- “БНХАУ, ОХУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, ач холбогдол” бодлогын судалгаа. Захиалагч: ЭЗХЯ. 2014 он (Гүйцэтгэгч: МУ-ын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, МУИС-ийн Бизнесийн сургуулийн судлаачид)
- Н.Отгонсайхан. Монгол улс, БНХАУ-ын хоорондын худалдааны өнөөгийн байдал. МУ-ын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн “Олон улс судлал” сэтгүүл. –УБ 2014. – № 1. – Х.45-55
- Монгол улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр
- Монгол улсын гаалийн статистик, 1997-2013 он
- <http://www.investmongolia.com>
- <http://www.trademap.org>
- <http://www.unctad.org>